**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2025/013/НА-СТА-ТТЗ**


| | |
|---|---|
| Баянхонгор<br>2025 он<br>Цахим хуудас: www.audit.mn | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор Ц.Дорж<br>Утас: 88114307 Цахим хаяг: Dorjts@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 15
3.5.1. Мөнгөн хөрөнгө ........ 15
3.5.2 Авлага ........ 15
3.5.3 Бараа материал ........ 16
3.5.7 Үндсэн хөрөнгө ........ 17
3.5.8 Өр төлбөр ........ 18
Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан ........ 18
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо ........ 19
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 19
3.7 Орлогын данс ........ 19
3.8 Зардлын данс ........ 20
3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 21
АУДИТЫН ТАЙЛАН ........ 23
4.1. Ерөнхий зүйл ........ 23
4.2 Материаллаг байдал ........ 24
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 24
4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 24
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 24
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 25
4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 25
4.9 Аудитын гол асуудал ........ 25
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 27

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2025.03.25 № 2/109

танай____________-ны № ______________ -т

БОГД СУМЫН ЗАСАГ
ДАРГА Л.ГАНАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Баянхонгор аймгийн Богд сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус сум нь 16 нэр төрлийн орлогоор 662,638.4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 753,052.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлогыг 113.6 хувь буюу 91,414.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 28,972.3

6425020502

мянга, үйл ажиллагааны орлого 47,144.1 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 22,628.5 мянга, ҮХЭХ борлуулсны орлого 4,972.0 мянган төгрөгөөр тус тус давж биелсэнтэй холбоотой бөгөөд 5 төрлийн 39,441.8 мянган төгрөгийн орлого тасарсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын 55 арга, хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс 94 хувиар үнэлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,151,831.3 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,988,490.1 мянган төгрөгийг зарцуулж 92.4 хувийн биелэлттэй байна.

Богд сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Сумын Засаг дарга санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлләэс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

[illegible]

[illegible] : procurement. bayankhongor@audit.gov.mn
[illegible] · 64101 · [illegible]: (976) 70442584
[illegible] · [illegible] 1 [illegible] · [illegible] · [illegible]
310 [illegible] · [illegible] 3

2024-02-22 [illegible] Б/102

[illegible]

[illegible] 8.9.3 [illegible] 2024 [illegible] 12 [illegible] 31 [illegible]

[illegible] 6.3.1 · 8 [illegible] 8.1 · [illegible] 8 [illegible] 8.9.3 [illegible] 2024 [illegible] 12 [illegible] 31 [illegible] 2024 [illegible] 12 [illegible] 31-[illegible]

[illegible]

[illegible]

[illegible] [signature] [illegible]

[illegible] ::
[illegible]
[illegible]
[illegible] ::
[illegible]
[illegible]
[illegible] ::
[illegible]
[illegible]

**[illegible]**

[illegible] ::
[illegible]
[illegible] :: [illegible]
[illegible]
[illegible]

**[illegible]**

[illegible] ::
[illegible] :: [illegible]
[illegible]
[illegible] 86.5 [illegible] ::
[illegible] 2024 [illegible]
[illegible] ::

**[illegible]**

[illegible] 5 [illegible] 39 441.8 [illegible] ::
[illegible] 4 972.0 [illegible]
[illegible] 11 [illegible] 28,972.3
753,052.6 [illegible] 113,6 [illegible] 91,414.5 [illegible]
[illegible] 16 [illegible] 662,638.4 [illegible]
[illegible] ::
[illegible]

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **707,683.1** | **697,754.7** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **416,755.7** | **372,233.3** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **416,755.7** | **372,233.3** |
| **31210** | **Төгрөг** | **416,755.7** | **372,233.3** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 416,755.7 | 372,233.3 |
| **33** | **АВЛАГА** | **179,404.3** | **219,891.1** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 551.7 |
| **33500** | **Бусад авлага** | **67,000.0** | **67,676.6** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 50,000.0 | 50,676.6 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 17,000.0 | 17,000.0 |
| **33600** | **Зээлийн авлага** | **112,404.3** | **151,662.8** |
| **33610** | **Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага** | **112,404.3** | **151,662.8** |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 112,404.3 | 151,662.8 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **69,511.7** | **83,630.3** |
| **35100** | **Түүхий эд материал** | **65.0** | **65.0** |
| 35130 | Эм боох материал | 65.0 | 65.0 |
| **35400** | **Хангамжийн материал** | **65,086.7** | **79,205.3** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,349.8 | 8,549.4 |
| 35420 | Аж ахуйн материал | 55,596.9 | 70,515.9 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 140.0 | 140.0 |
| 35600 | Мал амьтад | 4,360.0 | 4,360.0 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | **42,011.5** | **22,000.0** |
| 36100 | Барааны нөөц | 42,011.5 | 22,000.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,139,850.8** | **1,317,452.0** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,139,850.8** | **1,317,452.0** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,126,262.8** | **1,248,010.5** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 807,546.8 | 856,769.8 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (202,701.8) | (254,564.6) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 184,880.0 | 265,088.0 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (93,520.8) | (119,089.9) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 151,595.4 | 223,435.0 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (106,765.0) | (125,507.7) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 214,766.5 | 226,446.5 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (104,881.6) | (137,235.6) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 449,472.0 | 449,472.0 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (226,849.6) | (249,258.5) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 220,078.5 | 303,963.2 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (167,657.5) | (191,807.7) |
| 39217 | Ном | 300.0 | 300.0 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **13,588.0** | **69,441.6** |
| 39301 | Програм хангамж | 659.0 | 659.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (659.0) | (659.0) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,588.0 | 69,886.0 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | (444.4) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,847,533.9** | **2,015,206.8** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **433.5** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **433.5** | **-** |
| **41300** | **Өглөг** | **433.5** | **-** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 133.5 | - |
| **41360** | **Бусад өглөг** | **300.0** | **-** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 300.0 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,847,100.4** | **2,015,206.8** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,847,100.4** | **2,015,206.8** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 485,100.1 | 485,100.1 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 485,100.1 | 485,100.1 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,204,572.8** | **1,372,679.2** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 755,027.4 | 1,204,572.8 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 449,545.5 | 168,106.4 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 157,427.4 | 157,427.4 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,847,533.9** | **2,015,206.8** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,190,641.2** | **2,393,727.7** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **582,623.3** | **736,862.3** |
| **110** | **Орлогын албан татвар** | **262,246.3** | **544,115.0** |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | **262,246.3** | **544,115.0** |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | 207,225.7 | 329,973.2 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 19,363.1 | 153,164.8 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 33,323.5 | 53,505.0 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 2,334.0 | 7,472.0 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 80,426.7 | 92,511.7 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 1,671.5 | 2,387.7 |
| 113002 | Бууны албан татвар | 2,430.0 | 2,880.0 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 76,325.3 | 87,244.0 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | **239,950.3** | **100,235.6** |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | **29,913.7** | **34,820.8** |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 20,998.7 | 12,843.0 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | - | 2,516.6 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 8,915.0 | 19,461.3 |
| **1181** | **Газрын төлбөр** | **4,441.2** | **6,665.7** |
| 118101 | Газрын төлбөр | 4,358.2 | 5,138.0 |
| 118102 | Дуудлага худалдаа | 83.0 | 1,527.6 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | **204,347.1** | **58,749.2** |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 204,347.1 | 58,749.2 |
| **1183** | **Бусад татвар** | **1,248.4** | **-** |
| 118301 | Бусад татвар | 1,248.4 | - |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **365,131.8** | **480,344.5** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **365,131.8** | **480,344.5** |
| 120003 | Торгуулийн орлого | 3,315.0 | 8,744.0 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **25,386.5** | **46,659.9** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,986.5 | 25,173.8 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 21,400.0 | 21,486.1 |
| 120009 | Бусад орлого | - | 11.7 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 334,310.3 | 316,971.5 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 2,120.0 | 107,957.4 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,242,886.1** | **1,176,521.0** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **56,565.8** | **46,727.6** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,300.0 | 11,728.5 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 55,265.8 | 34,999.1 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **2,186,320.3** | **1,129,775.5** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,185,625.1 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 29,262.0 | - |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 690,442.4 | 881,947.6 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 280,990.8 | 247,827.9 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | - | **17.9** |
| 133002 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 17.9 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,728,595.7** | **2,225,621.3** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,728,595.7** | **2,225,621.3** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,510,742.8** | **2,193,727.3** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **465,479.0** | **769,316.8** |
| 210101 | Үндсэн цалин | 344,422.3 | 464,656.9 |
| 210102 | Нэмэгдэл | 99,536.5 | 270,369.2 |
| 210104 | Урамшуулал | 21,520.2 | 34,290.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **58,846.4** | **93,920.1** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,622.7 | 64,673.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,009.4 | 7,498.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,522.0 | 3,884.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,025.8 | 3,487.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,666.5 | 14,375.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **23,900.5** | **390,394.8** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,772.7 | 34,547.6 |
| 210302 | Түлш, халаалт | 17,127.8 | 351,317.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000.0 | 4,530.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **85,334.2** | **99,499.5** |
| 210401 | Бичиг хэрэг | 10,397.7 | 14,329.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 44,034.0 | 42,073.2 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,414.3 | 1,318.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 313.2 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 12,844.4 | 22,641.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,862.6 | 19,136.6 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,428.0 | - |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | 40.0 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,937.0** | **48,487.3** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 139.0 | 7,357.9 |
| 210602 | Тавилга | - | 2,792.2 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 3,200.0 |
| 210604 | Урсгал засвар | 8,798.0 | 35,137.2 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,892.0 | 11,780.3 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,808.0 | 11,780.3 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 84.0 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **705,142.4** | **551,839.5** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 700,080.3 | 546,289.1 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 800.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 762.7 | 614.3 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,123.7 | 590.7 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132.0 | 215.1 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,515.2 | 3,009.6 |
| 210807 | Газрын төлбөр | 1,528.5 | 320.8 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **153,211.3** | **228,489.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 45,546.9 | 41,286.3 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,917.0 | 11,670.6 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 105,747.4 | 175,532.1 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,217,853.0** | **31,894.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,948.0** | **31,894.0** |

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 26,279.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,948.0 | 5,614.3 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,214,905.0** | **-** |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 1,185,625.1 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,262.0 | - |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 17.9 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **462,045.5** | **168,106.4** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **12,500.0** | **-** |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | 12,500.0 | - |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **449,545.5** | **168,106.4** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **485,100.1** | **157,427.4** | **743,027.4** | **1,385,554.9** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **-** | **-** | **12,000.0** | **12,000.0** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **485,100.1** | **157,427.4** | **755,027.4** | **1,397,554.9** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **449,545.5** | **449,545.5** |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **485,100.1** | **157,427.4** | **1,204,572.8** | **1,847,100.4** |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **485,100.1** | **157,427.4** | **1,204,572.8** | **1,847,100.4** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **485,100.1** | **157,427.4** | **1,204,572.8** | **1,847,100.4** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 168,106.4 | 168,106.4 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **485,100.1** | **157,427.4** | **1,372,679.2** | **2,015,206.8** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,946,383.9** | **2,008,856.6** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **582,623.3** | **736,862.3** |
| **110** | **Орлогын албан татвар** | **262,246.3** | **544,115.0** |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | **262,246.3** | **544,115.0** |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | 207,225.7 | 329,973.2 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 19,363.1 | 153,164.8 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 33,323.5 | 53,505.0 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 2,334.0 | 7,472.0 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | **80,426.7** | **92,511.7** |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 1,671.5 | 2,387.7 |
| 113002 | Бууны албан татвар | 2,430.0 | 2,880.0 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 76,325.3 | 87,244.0 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | **239,950.3** | **100,235.6** |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | **29,913.7** | **34,820.8** |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 20,998.7 | 12,843.0 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | - | 2,516.6 |

| | | | |
|---|---|---|---|
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 8,915.0 | 19,461.3 |
| **1181** | **Газрын төлбөр** | **4,441.2** | **6,665.7** |
| 118101 | Газрын төлбөр | 4,358.2 | 5,138.0 |
| 118102 | Дуудлага худалдаа | 83.0 | 1,527.6 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | **204,347.1** | **58,749.2** |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 204,347.1 | 58,749.2 |
| **1183** | **Бусад татвар** | **1,248.4** | **-** |
| 118301 | Бусад татвар | 1,248.4 | - |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **120,874.5** | **97,161.9** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **120,874.5** | **97,161.9** |
| 120003 | Торгуулийн орлого | 3,315.0 | 8,744.0 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **117,559.5** | **88,406.2** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 117,430.6 | 65,915.3 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 128.9 | 22,490.9 |
| 120009 | Бусад орлого | - | 11.7 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,242,886.1** | **1,174,832.4** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **56,565.8** | **45,039.0** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 10,728.5 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 56,565.8 | 34,310.5 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **2,186,320.3** | **1,129,775.5** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,185,625.1 | - |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 29,262.0 | - |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 690,442.4 | 881,947.6 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 280,990.8 | 247,827.9 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **-** | **17.9** |
| 133002 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 17.9 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,323,385.4** | **1,657,196.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,323,385.4** | **1,657,196.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,105,182.4** | **1,628,895.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **467,256.3** | **769,448.1** |
| 210101 | Үндсэн цалин | 319,882.4 | 449,893.2 |
| 210102 | Нэмэгдэл | 142,914.7 | 285,983.8 |
| 210104 | Урамшуулал | 4,459.1 | 33,571.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **56,953.6** | **94,471.9** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,109.7 | 65,225.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,630.6 | 7,498.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,707.9 | 3,884.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 834.6 | 3,487.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,670.9 | 14,375.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **330,997.9** | **390,972.1** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 30,007.4 | 34,297.6 |
| 210302 | Түлш, халаалт | 294,070.6 | 351,894.4 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,919.9 | 4,780.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **71,437.5** | **83,072.7** |
| 210401 | Бичиг хэрэг | 9,477.1 | 11,059.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,888.1 | 36,826.6 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,982.1 | 2,056.4 |
| 210404 | Ном, хэвлэл | 492.0 | 48.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 13,693.7 | 27,343.8 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,904.6 | 5,738.6 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **39,650.5** | **58,467.6** |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 196.5 | 12,640.3 |
| 210602 | Тавилга | - | 9,011.0 |
| 210604 | Урсгал засвар | 39,454.0 | 36,816.3 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,542.0** | **11,466.6** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,542.0 | 11,466.6 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **76,658.7** | **79,987.2** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 70,196.2 | 74,571.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 800.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 762.7 | 614.3 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,123.7 | 587.7 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132.0 | 218.1 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,915.6 | 3,009.6 |
| 210807 | Газрын төлбөр | 1,528.5 | 185.8 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **52,685.9** | **141,009.6** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 49,222.9 | 127,905.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,463.0 | 13,104.5 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,218,203.0** | **28,300.9** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,298.0** | **28,300.9** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 22,602.7 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,298.0 | 5,698.3 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,214,905.0** | **-** |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 1,185,625.1 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,262.0 | - |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 17.9 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **622,998.6** | **351,660.0** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **395,440.3** | **396,182.4** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **395,440.3** | **396,182.4** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **395,440.3** | **396,182.4** |
| 220001 | Барилга байгууламж | 368,222.6 | 360,020.5 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 27,217.7 | 36,161.9 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(395,440.3)** | **(396,182.4)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **227,558.3** | **(44,522.4)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 189,197.4 | 416,755.7 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 416,755.7 | 372,233.3 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,151,831.3 | 1,988,490.2 | 163,341.1 | 92.4 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,758,790.7 | 1,648,469.7 | 110,321.0 | 93.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,751,890.7 | 1,642,771.5 | 109,119.2 | 93.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 815,256.2 | 769,448.1 | 45,808.1 | 94.4 |
| 210101 | Үндсэн цалин | 444,649.1 | 449,893.2 | (5,244.1) | 101.2 |
| 210102 | Нэмэгдэл | 335,652.5 | 285,983.8 | 49,668.7 | 85.2 |
| 210104 | Урамшуулал | 34,954.6 | 33,571.2 | 1,383.4 | 96.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 101,907.1 | 94,471.9 | 7,435.2 | 92.7 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,296.8 | 65,225.2 | 4,071.6 | 94.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,152.5 | 7,498.7 | 653.8 | 92.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,076.3 | 3,884.4 | 191.9 | 95.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,076.3 | 3,487.6 | 588.7 | 85.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,305.2 | 14,375.9 | 1,929.3 | 88.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 409,741.5 | 390,972.1 | 18,769.4 | 95.4 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 39,290.0 | 34,297.6 | 4,992.4 | 87.3 |
| 210302 | Түлш, халаалт | 366,051.5 | 351,894.4 | 14,157.1 | 96.1 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,400.0 | 4,780.0 | (380.0) | 108.6 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 85,151.9 | 83,072.7 | 2,079.2 | 97.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,362.6 | 11,059.3 | 303.4 | 97.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 38,600.0 | 36,826.6 | 1,773.4 | 95.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,785.3 | 2,056.4 | (271.1) | 115.2 |
| 210404 | Ном, хэвлэл | 144.0 | 48.0 | 96.0 | 33.3 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 27,760.0 | 27,343.8 | 416.2 | 98.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,500.0 | 5,738.6 | (238.6) | 104.3 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 59,841.8 | 58,986.6 | 855.2 | 98.6 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,298.8 | 13,159.3 | 1,139.5 | 92.0 |
| 210602 | Тавилга | 9,000.0 | 9,011.0 | (11.0) | 100.1 |
| 210604 | Урсгал засвар | 36,543.0 | 36,816.3 | (273.3) | 100.7 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,967.7 | 11,466.6 | 501.1 | 95.8 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,967.7 | 11,466.6 | 501.1 | 95.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 115,124.5 | 95,814.9 | 19,309.6 | 83.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 108,273.5 | 90,399.4 | 17,874.1 | 83.5 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 800.0 | 614.3 | 185.7 | 76.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 827.0 | 587.7 | 239.3 | 71.1 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 360.0 | 218.1 | 141.9 | 60.6 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564.0 | 3,009.6 | 554.4 | 84.4 |
| 210807 | Газрын төлбөр | 500.0 | 185.8 | 314.2 | 37.2 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 152,900.0 | 138,538.7 | 14,361.3 | 90.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 138,500.0 | 125,434.2 | 13,065.8 | 90.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,400.0 | 13,104.5 | 1,295.5 | 91.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,900.0 | 5,698.3 | 1,201.8 | 82.6 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,900.0 | 5,698.3 | 1,201.8 | 82.6 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 300.0 | - | 300.0 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,600.0 | 5,698.3 | 901.8 | 86.3 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 393,040.6 | 340,020.5 | 53,020.1 | 86.5 |
| 220001 | Барилга байгууламж | 393,040.6 | 340,020.5 | 53,020.1 | 86.5 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,151,831.3 | 1,964,180.7 | 187,650.6 | 91.3 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 262,644.6 | - | 262,644.6 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 262,644.6 | - | 262,644.6 | - |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,751,890.8 | 1,895,774.5 | (143,883.7) | 108.2 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,751,890.8 | 1,647,946.6 | 103,944.2 | 94.1 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | 247,827.9 | (247,827.9) | |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 137,295.9 | 68,406.2 | 68,889.7 | 49.8 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 66,172.9 | 65,915.3 | 257.6 | 99.6 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000.0 | 2,490.9 | (1,490.9) | 249.1 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 70,123.0 | - | 70,123.0 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 149,378.6 | (149,378.6) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 125,069.2 | (125,069.2) | |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **45,039.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **45,039.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **22,286.1** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **19,815.2** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,815.2 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,470.9** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,470.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **22,752.9** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **22,602.7** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 22,602.7 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **150.2** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 150.2 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **45,039.0** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **45,039.0** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,728.5 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 34,310.5 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх иргэдийн хууль ёсны эрх ашигийг хамгаалах ардчилал, шударга есыг тогтоох хууль дээдлэх төрийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх, ажил үйлчилгээг хөнгөн шуурхай жигд хүртээмжтэй явуулах, төсөв санхүүгийн хэмжээг тодорхойлох эцсийн үр дүнг үнэлж дүгнэх нийгмийн үйлчилгээний чанар үр ашгийг дээшлүүлэхэл гол зорилго оршино.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Богд сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Богдчууд бид Их Богд хайрхнаа дээдлэн, байгальдаа ээлтэй, хүний хөгжлийг хангасан, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжүүлсэн, аялал жуулчлалын бүс бүхий эдийн засагт суурилсан хөгжлийн загвар сум болно.” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

Хүний хөгжлийн орчныг бүрдүүлж, хүн амын тогтвортой өсөлтийг хангах,хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх нь байгууллагын эрхэм зорилт юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Богд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Богд сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ТОЛИЛУУЛГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Богд сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 167,672.8 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | |
|---|---|---|---|---|---|---|
| | дүн | эзлэх хувь | дүн | эзлэх хувь | дүн | эзлэх хувь |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 707,683.1 | 38.3 | 697,754.8 | 34.6 | (9,928.4) | (5.9) |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | 416,755.7 | 58.9 | 372,233.4 | 53.3 | (44,522.4) | 448.4 |
| АВЛАГА | 179,404.3 | 25.4 | 219,891.1 | 31.5 | 40,486.8 | (407.8) |
| УРЬДЧИЛГАА | | | - | | - | |
| БАРАА МАТЕРИАЛ | 69,511.6 | 9.8 | 83,630.3 | 12.0 | 14118.7 | (142.2) |
| НӨӨЦИЙН БАРАА | 42,011.5 | 5.9 | 22,000.0 | 3.2 | (20,011.5) | 201.6 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,139,850.8 | 61.7 | 1,317,452.0 | 65.4 | 177,601.2 | 105.9 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,042,886.1 | 61.7 | 2,396,019.5 | 65.4 | 353,133.4 | 105.9 |
| ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ | (903,035.3) | (44.2) | (1,078,567.5) | (45.0) | (175,532.2) | (49.7) |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,847,533.9** | **100** | **2,015,206.8** | **100** | **167,672.8** | **100** |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР | 433.5 | 0.0 | - | - | (433.5) | (0.3) |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,847,100.4 | 100.0 | 2,015,206.8 | 100.0 | 168,106.3 | 100.3 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,847,533.9** | **100** | **2,015,206.8** | **100** | **167,672.8** | **100** |

## 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.5.1. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 416,755.7 мянган төгрөг байсан бөгөөд эцсийн үлдэгдэл 372,233.3 мянган төгрөг болж 44,522.4 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө | 416,755.7 | 372,233.3 | -44,522.4 | -448.4 |
| **Дүн** | 416,755.7 | 372,233.3 | -44,522.4 | **-448.4** |

*Эх сурвалж: Богд сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 372,233.3 мянган төгрөг нь орон нутгийн Ерөнхий орлогын дансны үлдэгдэл 247,164.2 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 60,952.1 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 64,117.0 мянган төгрөг тус тус байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 179,404.3 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 219,891.1 мянган төгрөг болж 40,486.8 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл / мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагсадтай холбогдсон авлага | | 551.7 | 551.7 |
| Татаас санхүүжилтийн авлага | | | - |
| Байгууллагаас авах авлага | 50,000.0 | 50,676.6 | 676.6 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 17,000.0 | 17,000.0 | - |
| Хувь хүмүүст олгосон зээл | 112,404.3 | 151,662.8 | 39,258.5 |

| | | | |
|---|---|---|---|
| Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл | | | - |
| **Дүн** | 179,404.3 | 219,891.1 | 40,486.8 |

Эх сурвалж: *Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт авлагын 69.0 хувь буюу 151,662.8 мянган төгрөг нь сум хөгжүүлэх сангийн сангийн авлага, 25.0 хувь буюу 55,000.0 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага, 5,8 хувь буюу 688.6 мянган төгрөг нь ЗДТГ-ын авлага, 0.2 хувь буюу 539.7 мянган төгрөг нь ИТХ-ын авлага байна.

*Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засаг даргын Тамгын газар | 12,000.0 | 12,688.6 | 688.6 | 5.8 |
| ИТХ | | 539.7 | 539.7 | 0.2 |
| Соёл | | | 0.0 | 0.0 |
| ЭМТ | | | 0.0 | 0.0 |
| СХС | 112,404.3 | 151,662.8 | 39,258.5 | 69.0 |
| Цэцэрлэг | | | 0.0 | 0.0 |
| ЕБС | | | 0.0 | 0.0 |
| ОНХСан | 55,000.0 | 55,000.0 | 0.0 | 25.0 |
| **НИЙТ ДҮН** | **179,404.3** | **219,891.1** | **40,486.8** | **100.00** |

*Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 111,523.1 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 105,630.3 мянган төгрөг болж, 5,892.8 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | | | 0.0 |
| Эм боох материал | 65.0 | 65.0 | 0.0 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | | | 0.0 |
| Бэлэн бүтээгдэхүүн | | | 0.0 |
| Бичиг хэргийн материал | 9,349.7 | 8,549.4 | -800.3 |
| Аж ахуйн материал | 55,596.9 | 70,515.9 | 14,919.0 |
| Сэлбэг хэрэгсэл | 140.0 | 140.0 | 0.0 |
| Түлш, шатах тослох материал | | | 0.0 |
| Барилгын засварын материал | | | 0.0 |
| Хүнсний материал | | | 0.0 |
| Бусад хангамжийн материал | | | 0.0 |
| Нөөцийн бараа | 42,011.5 | 22,000.0 | -20,011.5 |
| Мал амьтад | 4,360.0 | 4,360.0 | 0.0 |
| **Дүн** | **111,523.1** | **105,630.3** | **-5,892.8** |

*Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл 105,630.3 мянган төгрөг болж өмнөх оноос 5,892.8 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 3,522.3 | 4,499.0 | 976.7 | 4.3 |
| ЗДТГ | 65,989.3 | 79,131.3 | 13,142.0 | 74.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Соёл | | | - | - |
| ЭМТ | | | - | - |
| ОНХС | 42,011.5 | 22,000.0 | (20,011.5) | 20.8 |
| ЕБС | | | - | - |
| Цэцэрлэг | | | - | - |
| **НИЙТ ДҮН** | **111,523.1** | **105,630.3** | **-5,892.8** | **100.0** |

*Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 289,342.9 мянган төгрөгийн бараа материалаас 181,385.5 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 107,957.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Мөн нийт хасагдсан 295,235.8 мянган төгрөгийн бараа материалаас 228,447.7 мянган төгрөгийг зарцуулсан, 42,011.5 мянган төгрөгийг шилжүүлсэн, 24,776.5 мянган төгрөгийг бусдаар зарцуулсан байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| Нэмэгдсэн | 289,342.9 | Хасагдсан | 295,235.8 |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 181,385.5 | Худалдсан, зарцуулсан | 228,447.7 |
| Хандиваар | | шилжүүлсэн | 42,011.5 |
| Шилжүүлсэн авсан | 107,957.4 | | |
| Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр | | Бусад | 24,776.6 |
| Бусад | | Бусад | |

*Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,042,886.2 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 2,396,019.6 мянган төгрөг болж 353,133.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **БИЕТ ХӨРӨНГӨ** | 2,028,639.1 | 2,325,474.5 | 296,835.4 | 97.1 |
| Барилга байгууламж, орон сууц | 807,546.8 | 856,769.8 | 49,223.0 | 35.8 |
| Тээврийн хэрэгсэл | 184,880.0 | 265,088.0 | 80,208.0 | 11.1 |
| Машин тоног төхөөрөмж | 151,595.4 | 223,435.0 | 71,839.6 | 9.3 |
| Тавилга эд хогшил | 214,766.5 | 226,446.5 | 11,680.0 | 9.5 |
| Зам гүүрийн байгууламж | 449,472.0 | 449,472.0 | 0.0 | 18.8 |
| Дуусаагүй барилга байгууламж | | | 0.0 | 0.0 |
| Номын фонд | 300.0 | 300.0 | 0.0 | 0.0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 220,078.4 | 303,963.2 | 83,884.8 | 12.7 |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | 14,247.0 | 70,545.0 | 56,298.0 | 2.9 |
| Программ хангамж | 659.0 | 659.0 | 0.0 | 0.0 |
| Бусад биет бус хөрөнгө | 13,588.0 | 69,886.0 | 56,298.0 | 2.9 |
| **НИЙТ ДҮН** | 2,042,886.1 | 2,396,019.5 | 353,133.4 | 100.0 |

*Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд Тайлант онд үндсэн хөрөнгө нь 353,133.4 мянган төгрөгөөр өссөн бөгөөд үүний шалтгаан нь ЗДТГ-ын үндсэн хөрөнгөн дээр аймгийн ХАА-н газраас газар тариалангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийг шилжүүлэн авсан, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгүүд нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлж байна. Үүнд:

-Тээврийн хэрэгсэл дээр 45,000.0 төгрөгийн хог тээврийн машин, 3 мотоцикл 9,241.3 мянган төгрөгөөр авсан, аймгийн ХАА-н газраас шилжүүлэн авсан трактор 22,466.7 мянган төгрөг

-Барилга байгууламж дээр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 2-р багийн төвийн их засвар хийж үндсэн хөрөнгийн үнэлгээг 39,223.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, хүнсний ногооны хүлэмжийн иж бүрдэл -10,000.0 мянган төгрөг

-Бусад үндсэн хөрөнгө дээр аймгийн ХАА-н газраас шилжүүлэн авсан газар тариалангийн тоног төхөөрөмж, багаж 60,884:8 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийсэн сумын төвийн гэрэлтүүлэг 15,000.0 мянган төгрөг, шинэ хогийн цэг 8,000.0 мянган төгрөг тус тус нэмэгдсэн байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 16,835.2 | 20,731.2 | 3,896.0 | 1 |
| ЗДТГ | 2,026,051.0 | 2,375,288.4 | 349,237.4 | 99 |
| Соёл | | | 0.0 | 0 |
| ЕБС | | | 0.0 | 0 |
| Цэцэрлэг | | | 0.0 | 0 |
| Эмнэлэг | | | 0.0 | 0 |
| ОНХСан | | | 0.0 | 0 |
| **НИЙТ ДҮН** | **2,042,886.2** | **2,396,019.6** | **353,133.4** | **100** |

*Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд 353,133.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 89.7 хувь буюу 316,971.5 мянган төгрөгийг хөрөнгийн үнэ төлбөргүй шилжүүлэн, бусдаар авсан нь голлох нөлөө үзүүлж байна .

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| | | | |
|---|---|---|---|
| Нэмэгдсэн | **353,133.4** | Хасагдсан | **0.00** |
| Худалдан авсан | 36,161.9 | Худалдсан | |
| Хандиваар | | Акталсан | |
| Шилжүүлэн авсан | 260,673.5 | Шилжүүлсэн | |
| Бусад | 56,298.0 | Бусад | |

*Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 433.5 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл нь 00 болж 433.5 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН | 433.5 | 0.0 | -433.5 | |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 133.5 | | (133.5) | |
| Татаас санхүүжилт шилжүүлгийн өглөг | | | - | |
| Байгууллагад төлөх өглөг | 300.0 | | (300.0) | |
| Хувь хүмүүст өгөх өглөг | | | - | |
| **Дүн** | 433.5 | - | (433.5) | |

Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 00.0 үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | | | - | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ЗДТГ | 433.5 | | (433.5) | |
| Орон нутгийн ерөнхий орлого | | | - | |
| ЕБС | | | - | |
| ЭМТ | | | - | |
| ОНХС | | | - | |
| Цэцэрлэг | | | - | |
| СХСан | | | - | |
| ДҮН | 433.5 | - | (433.5) | |

*Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,847,100.3 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 2,015,206.8 мянган төгрөг болж, 168,106.5 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/**

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 485,100.1 | 485,100.1 | - | 24.1 |
| Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 485,100.1 | 485,100.1 | - | 24.1 |
| **Хуримтлагдсан үр дүн** | 1,204,572.8 | 1,372,679.3 | 168,106.5 | 68.1 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 157,427.4 | 157,427.4 | - | 7.8 |
| **Дүн** | 1,847,100.3 | 2,015,206.8 | 168,106.5 | 100 |

Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 168,106.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2023.12.18 -ний өдрийн хуралдаанаар 13/05 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 505,022.1 мянга, хүү торгуулийн орлогыг 4,000.0 мянга, нийт 509,022.1 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2024.09.23-ний өдрийн 17/17 дугаар тогтоолоор 152,616.0 мянган төгрөгийн орлогыг нэмж тодотгосон байна.

*Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| 1.Татварын орлого | 656,638.1 | 742,992.5 | 86,354.4 | 113.2 |
| ЦХТА орлого /суутган/ | 301,000.0 | 329,972.3 | 28,972.3 | 109.6 |
| ҮХЭХ-ийн албан татвар | 2,100.0 | 2,356.9 | 256.9 | 112.2 |
| Бууны татвар | 3,570.0 | 2,910.0 | (660.0) | 81.5 |
| ИОТХ | 105,900.0 | 153,044.1 | 47,144.1 | 144.5 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 10,000.0 | 12,829.7 | 2,829.7 | 128.3 |
| Хадгаламжийн хүүгийн орлого | 35,300.0 | 57,928.5 | 22,628.5 | 164.1 |
| Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого | 2,500.0 | 7,472.0 | 4,972.0 | 298.9 |
| Малд тоо толгойн албан татвар | 86,515.1 | 87,414.3 | 899.2 | 101.0 |
| Газрын төлбөр | 2,300.0 | 5,129.7 | 2,829.7 | 223.0 |
| Газрын дуудлага худалдаа | 600.0 | 1,527.6 | 927.6 | 254.6 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 26,800.0 | 21,130.1 | (5,669.9) | 78.8 |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 76,160.0 | 58,749.1 | (17,410.9) | 77.1 |
| ТТАМАТөлбөр | 2,000.0 | 2,516.5 | 516.5 | 125.8 |
| Ус рашааны төлбөр | | | - | |
| Газрын тос | 1,893.0 | 11.7 | (1,881.3) | 0.6 |
| 2.Татварын бус орлого | 5,000.0 | 10,060.1 | 5,060.1 | 201.2 |
| 2.1.Хүү торгуулийн орлого | 4,000.0 | 8,374.0 | 4,374.0 | 209.4 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,000.0 | 1,686.1 | 686.1 | 168.6 |
| **Нийт дүн** | 662,638.1 | 753,052.6 | 91,414.5 | 113.6 |

*Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 113.3 хувь буюу 91,414.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 28,972.3 мянга, ҮХЭХ-ийн алан татвар 256.9 мянга, бууны албан татвар 600.0 мянга, иргэний орлого тодорхойлох хуудсаар ногдуулсан албан татвар 47,144.1 мянга, улсын тэмдэгтийн хураамж 2,829.7 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 22,628.5 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 4,972.0 мянга, малын тоо толгойн албан татвар 899.2 мянга, газрын төлбөр 2,829.7 мянга, газрын дуудлага худалдаа 927.6 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 516.5 мянга, хүү торгуулийн орлого 4,374.0 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин иргэний бууны татвар 660.0 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 5,669.9 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөр 17,410.9 мянга, газрын тосны орлого 1,881.3 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 1,686.1.0 мянган төгрөгийн орлого оруулж үүргээ биелүүлээгүй байна

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 66,172.9 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 40,741.5 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

### 3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,151,831.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,988,490.2 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,648,469.7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 340,020.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

*Хүснэгт №14.Төсвийн гүйцэтгэл /мянган төгрөг/*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **Богд сумын Засаг дарга** | **2,151,831.3** | **1,988,490.1** | **-163,341.2** | **92.4** |
| 2 | 70105-80101 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага | 181,232.3 | 156,628.3 | 24,604.0 | 86.4 |
| 3 | 70105-80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 2,000.0 | 1,173.2 | -826.8 | 58.7 |
| 4 | 70106-80101 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 729,328.5 | 710,466.3 | -18,862.2 | 97.4 |
| 5 | 70106-80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал | 193,553.9 | 167,558.9 | -25,995 | 86.6 |
| 6 | 70106-80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 4,000.0 | 3,925.0 | -75.0 | 98.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | 70106-81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 40,000.0 | 39,951.2 | -48.8 | 99.9 |
| 8 | 70106-81549 Ахмадын сан | 2,000.0 | 1,993.0 | -7.0 | 99.7 |
| 9 | 70106-81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал | 83,133.5 | 69,053.5 | 14,080.0 | 83.1 |
| 10 | 70106-82212 хур хог хаягдал, орчны бохирдол | 26,800.0 | 26,204.0 | -596.0 | 97.8 |
| 11 | 70106-82310 Гамшгаас сэргийлэх сургалт, сурталчилгааны зардал | 3,500.0 | 2,990.0 | -510.0 | 85.4 |
| 12 | 71602-80111 Эмнэлгийн тусламж үйлчилгээ | 74,814.8 | 74,524.6 | -290.2 | 99.6 |
| 13 | 71702 -80111 Соёл урлаг | 97,321.6 | 96,392.9 | -928.7 | 99.0 |
| 14 | 71801 -80111 Сургуулийн өмнөх боловсрол | 50,780.2 | 49,787.4 | -992.8 | 98.0 |
| 15 | 71802-80111 Ерөнхий боловсрол | 177,910.9 | 166,171.3 | -11,739.6 | 93.4 |
| 16 | 70503-80904 Орон нутгийн зорилтот орон оруулалт | 43,880.0 | 6,513.6 | -37,367.4 | 14.8 |
| 17 | 70503-83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох | 262,644.5 | 246,992.2 | -15,652.3 | 94.0 |
| 18 | 70503-83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар | 86,515.1 | 86,514.7 | -0.4 | 99.9 |
| 19 | 72101-82611 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих | 92,415.0 | 81,650.0 | -10,765 | 88.3 |
| | **Нийт дүн** | **2,151,831,3** | **1,988,490.1** | **-163,341.2** | **92.4** |

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

## 3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2023.12.18-ний өдрийн хуралдаанаар 13/05 дугаар тогтоолоор нийт 2,093,533.1 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2024.09.23-ний өдрийн 17/17 дугаар тогтоолоор 58,298.2 мянган төгрөгийг нэмж тодотгосон байна.

*Хүснэгт №15. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Тодотгосон төсөв | Зөрүү |
|---|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 96,592.2 | 182,184.5 | 183,232.3 | -86,640.1 |
| Засаг даргын Тамгын газар | 899,800.6 | 1,061,839.9 | 1,082,315.9 | -182,515.3 |
| Сургууль | 52,301.2 | 176,527.8 | 177,910.9 | -125,609.7 |
| Цэцэрлэг | 16,076.6 | 49,580.2 | 50,780.2 | -34,703.6 |
| Эрүүл мэндийн төв | 94,500.4 | 74,814.8 | 74,814.8 | 19,685.6 |
| Соёлын төв | 17,685.0 | 97,321.6 | 97,321.6 | -79,636.6 |
| Сум хөгжүүлэх сан | | 92,415.0 | 92,415.0 | -92,415.0 |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 358,849.3 | 393,040.6 | -393,040.6 |
| **Нийт дүн** | 1,176,956.0 | 2,093,533.1 | 2,151,831.3 | -974,875.3 |

*Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2023.12.18-ний өдрийн хуралдаанаар 13/05 дугаар тогтоолоор анх 2,093,5334.1 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2024.09.23-ний өдрийн 17/17 дугаар тогтоолоор 58,298.2 мянган төгрөгөөр өсгөж 2,151,831.3 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 2,151,831.3 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 262,644.6 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэгээс 881,947.6 мянган, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоос 66,172.9 мянган, сумын төсвийн урьд оны үлдэгдлээс 209,305.1мянган, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 26,242.1 мянган, хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлээс 43,880.9 мянган, сумын орон нутгийн орлогоос 661,638.1 төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 881,947.6 мянган, орон нутгийн орлогоос мянган, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 247,827.9 мянган, туслах үйл ажиллагааны орлогоос 2,490.9 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авсан ба урьд оны үлдэгдлээс санхүүжих санхүүжилтийг бүрэн авч 98,523.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №16. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| ЗДТГ | 1,082,315.9 | 1,022,141.9 | 60,174.0 | 94.4 |
| ИТХ | 183,232.3 | 157,801.5 | 25,430.8 | 86.1 |
| Соёлын төв | 97,321.6 | 96,392.9 | 928.7 | 99 |
| Хоршоо хөгжүүлэх сан | 92,415.0 | 81,650.0 | 10,765.0 | 88.4 |
| Сургууль | 177,910.9 | 166,171.3 | 11,739.6 | 93.4 |
| Цэцэрлэг | 50,780.2 | 49,787.4 | 992.8 | 98 |
| ЭМТ | 74,814.8 | 74,524.6 | 290.2 | 99.6 |
| ОНХС | 393,040.6 | 340,020.5 | 53,020.1 | 86.5 |
| **Нийт дүн** | **2,151,831.3** | **1,988,490.1** | **163,341.2** | **92.4** |

*Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,988,490.1 мянган төгрөг буюу 92,4хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардал 60,174.0 мянган төгрөг , хоршоо хөгжүүлэх сангийн зардлыг 10,765.0 мянган, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 53,020.1мянган, ИТХ-ын урсгал зардлаас 25,430.8 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.9.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас ЗДТГ-т хуваарилсан 826.5 мянган төгрөг, ИТХ-д 9,902.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, мөн төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын хүрээнд 34,310.5 мянган төгрөгийн орлого олж бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 19,815.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 2,470.9 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд 22,602.7 мянган төгрөгийг тус тус зарцуулж үлдэгдэл 150.2 мянган төгрөгийг орон

нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх орлогын дансанд төвлөрүүлсэн.

*Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | ИТХ | ЗДТГ | НИЙТ |
|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | 9,902.0 | 35,137.0 | 45,039.0 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,902.0 | 826.5 | 10,728.5 |
| Төсөвт байгууллагийн үндсэн үйл ажиллагааныхүрээнд бий болсон орлого | | 34,310.5 | 34,310.5 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | 9,902.0 | 34,986.8 | 44,888.8 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 19,815.2 | 19,815.2 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 2,470.9 | 2,470.9 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | 9,902.0 | 12,700.7 | 22,602.7 |
| **Төсөвт төвлөрүүлсэн** | 0.0 | 150.2 | 150.2 |

*Эх сурвалж: Богд сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**АУДИТЫН ТАЙЛАН**

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Богд сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Дорж гүйцэтгэж аудитын менежер М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Богд сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугээр сарын 10-ний өдрийн 1а/42 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Богд сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Л.Гансаа, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Э.Адъяа нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 65 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 2,225,771.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 22,257.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 14,467.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн* хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

### 4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд 2024 онд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 123 мэдээллийг хугацаанд нь 20 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл мэдээлэх хугацаа болоогүй байна.

### 4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Богд сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

### 4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 алдаа зөрчил илэрснээс зөрчлийг арилгах албан шаардлага, төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа хэрэгжилтийг сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 1а/142 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 20* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | | | 100 |
| Нийт | 1 | 0 | 1 | 0 | | | 100 |

### 4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

### 4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 40,000.0 төгрөгөөр баталж 39,951.0 мянган төгрөгийг зарцуулж 49.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 35.9 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд өвс тэжээл, 64.1 хувийг 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд тус тус зарцуулжээ.

### 4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж 94 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,151,831.3 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,988,490.1 мянган төгрөгийг зарцуулж 92.4 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 16 нэр төрлийн орлогоор 662,638.4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 753,052.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлогыг 113.6 хувь буюу 91,414.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 28,972.3 мянга, үйл ажиллагааны орлого 47,144.1 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 22,628.5 мянга, ҮХЭХ борлуулсны орлого 4,972.0 мянган төгрөгөөр тус тус давж биелсэнтэй холбоотой бөгөөд 5 төрлийн 39,441.8 мянган төгрөгийн орлого тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Богд сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Богд сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

*Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн*

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо | | | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Гүйцэтгэсэн | | Бүгд | Үүнээс | | | |
| | | | Бие дааж дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| **ЗДТГ** | 1 | 1 | 1 | | | 1 | | | |
| **ИТХурал** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **ОНХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **СХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **НИЙТ ДҮН** | **4** | **4** | **1** | **3** | **0** | **1** | **0** | **0** | **0** |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 78,399.9 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 4,213.2 мянган төгрөгийн 2 залруулга, 10,373.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 63,813.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн*

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Залруулга | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн зөрчил | | | | | | | | | | |
| ИТХурал | | | | | | | | | | |
| ЗДТГ | 3 | 23026.2 | 2 | 4,213.2 | | | 1 | 18,813.0 | | |
| ОНХСан | 1 | 45,000.0 | | | | | 1.00 | 45,000.0 | | |
| СХС | 1 | 10373.7 | | | 1 | 10,373.7 | | | | |
| СТА зөрчлийн дүн | 5 | 78,399.9 | 2 | 4,213.2 | 1 | 10,373.7 | 2.00 | 63,813.0 | - | - |
| СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | |
| ЗДТГ | 0 | - | | | | | | | | - |
| ОНХСан | 0 | - | | | | | | | | |
| ИТХурал | 0 | | | | | | | | | - |
| СХС | 0 | - | | | | | | | | |
| Нийцлийн аудитын дүн | 0 | - | - | - | - | - | - | - | | - |
| Нийт дүн | 5 | 78,400 | 2 | 4,213 | 1 | 10,373.7 | 2 | 63,813 | 0 | - |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн*

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 78,399.9 мянган төгрөгийн 5 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой зөрчил илрээгүй байна.

Хүснэгт 19. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /мянган төгрөг/ | Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт. | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Засаг даргын Тамгын газар | | 23,026.2 | | | |
| 1 | Нийгмийн даатгалын шимтгэлийн 11,9 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 заалт зөрчсөн байна. | 11.9 | Залруулга | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Бурмаа З.Нанжидмаа |
| 2 | Байгууллагын нярав 2024 оны шатахууны тайлангийн орлогыг илүү, аж ахуйн тайлангийн | 4,201.3 | Залруулга | Төсвийн захирагч, | Б.Бурмаа З.Нанжидмаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зарцуулалтыг илүү тайлагнасан байхад байгууллагын нягтлан бодогч хяналт тавьж ажиллаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг зөрчсөн байна. | | | нягтлан бодогч | |
| 3 | Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 18,813.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээ мэдээлээгүй зөрчил иозрсэн. | 18,813.0 | Албан шаардлага | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Бурмаа З.Нанжидмаа |
| | | | | | |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | | - | | | |
| | | | | | |
| Сум хөгжүүлэх сан | | 10,373.7 | | | |
| 1 | Тайлант оны жилийн эцсийн байдлаар 9 зээлдэгчийн 142,877.5 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагаас 2 зээлдэгчийн 10,373.7 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн байна. | 10,373.7 | Төлбөрийн акт | Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч | Л.Ганаа Э.Адъяа Б.Хандмаа |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 45,000.0 | | | |
| 1 | Иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. | 45,000.0 | Албан шаардлага | Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч | Л.Ганаа Э.Адъяа Б.Хандмаа |
| | Нийт дүн | 78,399.9 | | | |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2 зөрчил[1] илэрснээс 2 албан шаардлага өгөв.

### 5.1 Албан шаардлага

5.1.1 Богд сумын сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг ирүүлэхдээ УСНББОУС 1 - Санхүүгийн тайлангийн толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт дагуу “санхүүгийн тайлангийн тодруулга” бэлтгэж ирүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт “санхүүгийн тайлангийн тодруулга” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгыг бичиж байх албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Богд сумын Засаг даргын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг сумын ИТХ -аар батлуулсан боловч төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалт дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр арга хэмжээ, хүрсэн үр дүнгийн тайланг ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалт “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргахдаа Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

(мянган төгрөг)

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүнгийн тайлан цэвэрлээгүй | 1 | 18,490.3 | | | 1 | 18,490.3 | 1 | 18,490.3 | | |
| **Дүн** | **1** | **18,490.3** | | | **1** | **18,490.3** | **1** | **18,490.3** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Богд сумын сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг ирүүлэхдээ УСНББОУС 1 - Санхүүгийн тайлангийн толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт дагуу “санхүүгийн тайлангийн тодруулга” бэлтгэж ирүүлээгүй. | 1 | - | | | 1 | - | | |
| Богд Засаг даргын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг сумын ИТХ -аар батлуулсан боловч төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалт дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр арга хэмжээ, хүрсэн үр дүнгийн тайланг ирүүлээгүй байна. | 1 | - | | | 1 | - | | |
| Дүн | **2** | **-** | | | **2** | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |

-----------oOo-----------